



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 3 дугаар хуралдааны тэмдэглэлд:

III.1 "ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын Бурханы Шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн 1080 лам хурах "Их Цогчин Дуган"-ын барилга болох Батцагаан дуганы тухай

ТЭМДЭГЛЭСЭН НЬ:

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны захиалгаар, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын Баянгол дүүрэг, төв гандангийн хашаанд баригдсан Монголын Бурханы Шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн 1080 лам хурах "Их Цогчин Дуган"-ын барилга болох Батцагаан дуган 2009 онд баригдаж эхэлсэн ба 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдөр Улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан. Улсын төсвийн тухай 2008-2020 оны хуулиудад санхүүжилт нь батлагдаж, гүйцэтгэлээр улсын төсвөөс нийт 24,647.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Батцагаан дуганы барилга, тоног төхөөрөмжийг:

1. Монголын Бурханы Шашинтны төв Гандантэгчэнлин хийд (шашны байгууллага)-ийн өмчлөлд шилжүүлэх тухай хуулийн төслийг Хууль, тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн Хууль зүй, дотоод хэргийн яам, Соёлын яамтай хамтран боловсруулж Засгийн газарт хүргүүлэх;
2. Төрийн өмчид бүртгэж, Соёлын яаманд эзэмшүүлэх;
3. Монголын Бурханы Шашинтны төв Гандантэгчэнлин хийд (шашны байгууллага)-д хугацаагүй, үнэ төлбөргүй ашиглуулах асуудлыг дэмжиж, Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэв" гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



132320704
3-r huraldaan.docx